

**2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 04 дүгээр сарын 28-ны “Баасан” гарагийн 12:00 цагаас өмнө e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

Биелэлтийг ирүүлэхдээ үүрэг даалгавар бүрийн хэрэгжилтийн хувийг тодорхой бичиж ирүүлнэ үү.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
<b>БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>		
1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах тул Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль, журамд нийцүүлэн ил тод, шуурхай зохион байгуулан, ажлын уялдаа холбоог сайжруулж, бүх үе шатанд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах.	СТСХ, ХААА
2	Нийслэлд төвлөрүүлэх төсвийн орлогын биелэлтийг жигд хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.	СТСХ, ХААА
<b>ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД</b>		
3	Хүүхэд, багачуудын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор нийслэлийн хэмжээнд “Хүүхдэд ээлтэй хот” болгох аяныг эхлүүлж зохион байгуулах.	НХХ, Боловсролын хэлтэс, ГБХЗХХ
4	Газрын зөрчил арилгаж гарааш буулгасан талбайд тохижилтын нэгдсэн зураг төслийг боловсруулан баталж, тохижуулах ажлаа эрчимжүүлэх.	ТХҮХ
5	2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр саналыг хүргүүлж ажиллах.	ТХҮХ
6	2023 онд нийслэлд хийгдэх зам, инженерийн байгууламжийн бүтээн байгуулалт, засварын ажилтай холбоотойгоор авто замын хөдөлгөөн болон хэрэглэгчдийн цахилгаан, ус түгээлтийг хаах, нээх хугацааг иргэд, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах.	ТХҮХ, УСАТ, Илч-Орд ОНӨААТҮГ
7	Нөөцийн махны үнэ өндөр байгаа талаар иргэдээс гаргаж байгаа гомдол, хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлан, махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, махны чанарт онцгой анхаарч хяналт тавьж ажиллах.	ТХҮХ
8	Засгийн газрын Шилэн ажиллагааны хүрээнд 2000 оноос хойш газрын чиглэлээр гаргасан захирамж, барилгын А даалгавар болон бусад тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг <a href="https://shilen.gov.mn/">https://shilen.gov.mn/</a> сайтад байршуулах ажлуудыг эрчимжүүлж ажиллах.	ГЗБА
9	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн	ЗДТГ

	шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх, хариуцлагагүй хандсан албан хаагч болон удирдлагад хариуцлага тооцож ажиллах.	
10	Нийслэлийн хэмжээнд орон сууцны зориулалттай барилгын 1 давхрыг өргөтгөөд үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын барилга, байгууламжид газар хөдлөлттэй холбоотой эрсдэлийн үнэлгээ хийлгүүлж, цаашид арга зүйгээр хангах, зөвлөн туслах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	ОБХ, ТХҮХ
<b>ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
11	2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдах “Улаанбаатар марафон-2023” УАШТ-ий бэлтгэлийг сайтар хангах, тэмцээнд оролцогчдод хоол хүнсээр үйлчлэх нөхцлийг бүрдүүлж, худалдаа үйлчилгээг зохион байгуулах	ТХҮХ, ААНБ-ууд
12	“Багахангай лиг 2023” дүүргийн аварга шалгаруулах “Гар бөмбөг”-ийн тэмцээний хаалтын арга хэмжээнд зориулан тэмцээнд оролцсон багууд бэлтгэлийн хувцсаар жигдэрч, зураг авахуулахад идэвхтэй хамрагдах.	НХХ, БТСХ, ААНБ-ууд
13	Гамшгаас хамгаалах стратегийн команд штабын дадлага сургуулийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах хүрээнд дэд ажлын хэсгүүдийг хуралдуулж, идэвхжүүлэн, төлөвлөгөөнд тодотгол хийлгэх.	ОБХ, ААНБ-ууд,
14	Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд оролцогчдын ирц, үүргийн биелэлт, үр дүнг тооцож, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэн танилцуулах.	ТЗУХ
15	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын санал асуулгын талаар иргэдэд мэдээлэл хүргэж, санал авах ажлаа эрчимжүүлэх	СТСХ, Хороод, ААНБ-ууд